



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,  
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

АЙМАГ (НИЙСЛЭЛ)-ИЙН НИЙГМИЙН  
ДААТГАЛЫН ХЭЛТЭС (ГАЗАР)-ИЙН  
ДАРГА НАРТ

2022 06.10 № 01/1114  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**2022 оны тодотгосон төсвийн  
хуваарь хүргүүлэх тухай**

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын болон нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн 2022 оны тодотгосон төсвийн хуваарь, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн А/96 дугаар тушаалаар баталсан аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын болон нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2022 оны тодотгосон төсвийн сар, улирлын хуваарийг тус тус хүргүүлж байна.

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны тодотгосон төсвийн хуваарьт дараах өөрчлөлтүүд орсон болно. Үүнд:


1. Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 107 дугаар тогтоолоор санхүүжилтийн хагас бие даасан тогтолцоонд шилжсэн салбарууд болох боловсрол, эрүүл мэнд, соёл, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн баталсан. Энэхүү арга хэмжээнд нийтлэг үйлчилгээний төрийн албан хаагч хамрагдаагүй тул эдгээр албан хаагчийн цалингийн шатлалыг тухайн зэрэглэлийн 5 дугаар шатлалд шилжүүлэн 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тооцож, төсөвт байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн төсвийг 505.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.

2. Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хуулийн дагуу даатгуулагчид буцаан олгох нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээг 150.6 сая төгрөгөөр баталж, уг шимтгэлийг улсын төсвөөс олгохоор шийдвэрлэсэн.

3. Төрийн хэмнэлтийн тухай 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг нийт дүнгээр 163.9 сая төгрөгөөр бууруулан баталсан.

Иймд батлагдсан төсвийг дахин хувиарилах, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх замаар сангийн орлогын бүрдүүлэлтийг сайжруулах, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг барагдуулахад онцгой анхаарч, үйл ажиллагааны зардлын төсвийг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулахыг Та бүхэнд үүрэг болгож байна.

ДАРГА



Д.ЗОРИГТ



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А196

Улаанбаатар хот

Г 2022 оны тодотгосон төсвийн  
хуваарь батлах тухай Г

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хууль, Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6 дахь заалт, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-ийн 3.2.4, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, батлагдсан төсөв хуваарилах журам”-ын 7.6, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн “2022 оны тодотгосон төсвийн хуваарийг батлах тухай” 3 дугаар тогтоол, Сангийн сайдын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн “Төсвийн хуваарь батлах тухай” 95 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2022 оны тодотгосон төсвийн сар, улирлын хуваарь”-ийг нэгдүгээр хавсралтаар, “Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2022 оны тодотгосон төсвийн хуваарь”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

Хоёр. Төсвийн санхүүжилтийг баталсан хуваарийн дагуу олгож ажиллахыг Санхүү, бүртгэлийн газар /Б.Даваахүү/, төсвийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар /Ц.Ганцэцэг/-т тус тус даалгасугай.

Гурав. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд нь хяналт, тавьж төсвийн сахилгыг ханган ажиллахыг нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудын төсвийг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны “Төсвийн хуваарь батлах тухай” А/03, “2022 оны тодотгосон төсвийн хуваарь батлах тухай” А/42, “2022 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” А/60 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Тав. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Б.Батсүх/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЗОРИГТ



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

2022 оны тодотгосон төсвийн хуваарь  
батлах тухай

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хууль, Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.6 дахь заалт, Улсын Их Хурлын байнгын хорооны 2018 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм”-ийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тэтгэвэр авагчдын тэтгэврийн нэмэгдэлд зарцуулахаар батлагдсан хөрөнгийн эх үүсвэрт шаардагдах 300.0 тэрбум төгрөгийг тэтгэврийн даатгалын сангийн өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан орлогоос буюу харилцахын мөнгөн хөрөнгөөс зарцуулахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т зөвшөөрсүгэй.

2. “Нийгмийн даатгалын сангийн 2022 оны тодотгосон төсвийн нарийвчилсан хуваарь”-ийг нэгдүгээр хавсралтаар, “Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2022 оны тодотгосон төсвийн хуваарь”-ийг хоёрдугаар хавсралтаар, “Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2022 оны төсвийн хуваарь”-ийг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

3. Нийгмийн даатгалын сангийн 2022 оны тодотгосон төсвийн хуваарийг нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлж, төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т даалгасугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Г.Банзрагч/-нд үүрэг болгосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны “2022 оны төсвийн хуваарь батлах тухай” 23, 2022 оны “2022 оны тодотгосон төсвийн хуваарь батлах тухай” 02 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

А.АРИУНЗАЯА



**НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН  
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УРСГАЛ  
ЗАРДЛЫН ТОДОТГОСОН ТӨСӨВ**

Зардлын төрөл		Мөрийн дугаар	Дүн (мян.төг)
<b>A</b>		<b>Б</b>	<b>36</b>
1	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1</b>	<b>524,687.7</b>
	<b>Бараа, ажил үйлчилгээний зардал</b>	<b>2</b>	<b>517,269.7</b>
	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>3</b>	<b>424,055.7</b>
	Үүнээс		
	Үндсэн цалин	4	317,384.4
	Нэмэгдэл	5	59,156.3
	Унаа хоолны хөнгөлөлт	6	46,640.0
	Урамшуулал	7	875.0
	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>8</b>	<b>49,969.6</b>
	Үүнээс		
	Тэтгэврийн даатгал	9	34,210.2
	Тэтгэмжийн даатгал	10	3,939.9
	ҮОМШ свчний даатгал	11	3,151.8
	Ажилгйдлийн даатгал	12	788.1
	Эрүүл мэндийн даатгал	13	7,879.6
	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14</b>	<b>-</b>
	Үүнээс		
	Гэрэл цахилгаан	15	-
	Тvlш, халаалт	16	-
	Цэвэр, бохир ус	17	-
	Байрны түрээс	18	-
	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19</b>	<b>14,087.4</b>
	Үүнээс		
	Бичиг хэрэг	20	2,811.0
	Тээвэр, шатахуун	21	4,668.0
	Үүнээс		
	Хэлтсийн албан хэрэгцээний	22	4,668.0
	Сумын байцаагчид олгох	23	-
	Шуудан,холбоо, интернэтийн төлбөр	24	3,758.4
	Хог хаягдал зайлуулах, устгал, ариутгал	25	-
	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26	2,850.0
	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>27</b>	<b>3,299.0</b>
	Үүнээс		
	Багаж, техник, хэрэгсэл	28	1,874.0
	Урсгал засвар	29	1,425.0
	<b>Томилолтын зардал</b>	<b>30</b>	<b>427.4</b>
	Үүнээс		
	Гадаад албан томилолт	31	-
	Дотоод албан томилолт	32	427.4
	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>33</b>	<b>17,830.6</b>
	Үүнээс		
	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний	34	7,000.0
	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	35	6,000.0
	Даатгалын үйлчилгээ	36	2,000.0
	Тээврийн хэрэгслийн татвар	37	664.3
	Мэдээллийн технологийн үйлчилгээ	38	-
	Газрын төлбөр	39	2,000.0
	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	40	166.3
	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	41	-
	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>42</b>	<b>7,600.0</b>
	Үүнээс		
	Бараа үйлчилгээний бусад зардал /Ахмадын сан/	43	-
	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	44	7,600.0
	<b>Урсгал шилжүүлэг /Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал,</b>	<b>45</b>	<b>7,418.0</b>
	Үүнээс		
	Бусад ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	46	7,418.0
	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47	-
	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48	-
2	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>49</b>	<b>524,687.7</b>
3	<b>Нийгмийн даатгалын сангаас</b>	<b>50</b>	<b>524,687.7</b>
4	<b>Эрүүл мэндийн даатгалын сангаас</b>	<b>51</b>	<b>-</b>
5	<b>Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих</b>	<b>52</b>	<b>-</b>

НИСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УРСГАЛ ЗАРДЛЫН 2022 ОНЫ ТОДОТГОСОН ТӨСВИЙН САР, УЛИРЛЫН ХУВААРЬ

Мөнгөн дугаар	Нийт дүн	Зардлын төрөл												10 сар	11 сар	12 сар	4-р улирал	
		1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	3-р улирал							
А																		
ЗАРДАЛ																		
1	524 687.7	41 420.3	54 656.0	62 435.6	158 512.1	38 490.3	38 490.3	46 337.0	38 797.2	123 624.5	46 513.8	36 595.3	41 248.5	124 347.6	40 180.4	38 910.5	39 112.6	118 203.5
2	517 269.7	40 302.3	49 331.0	63 553.8	153 187.1	38 490.3	38 490.3	44 894.0	38 797.2	122 181.5	46 513.8	36 595.3	40 596.5	123 697.6	40 180.4	38 910.5	39 112.6	118 203.5
3	509 285.2	40 302.3	44 346.5	62 435.6	147 084.6	38 490.3	38 490.3	43 012.0	38 797.2	120 299.5	46 513.8	36 595.3	40 596.5	123 697.6	40 180.4	38 910.5	39 112.6	118 203.5
4	423 180.7	30 874.3	30 874.3	58 174.3	116 922.9	30 874.3	30 874.3	34 237.0	34 237.0	99 346.3	37 212.7	31 633.1	34 423.0	103 288.8	34 423.0	34 423.0	34 794.7	103 640.7
5	437 384.4	22 093.2	22 093.2	46 393.2	90 579.6	22 093.2	22 093.2	25 455.9	25 455.9	73 005.0	27 595.3	23 589.0	25 589.0	76 766.9	25 589.0	25 589.0	25 854.9	77 032.9
6	519 156.3	4 910.0	4 910.0	4 910.0	14 730.0	4 910.0	4 910.0	4 910.0	4 910.0	14 730.0	5 983.2	4 495.9	4 939.6	14 818.7	4 939.6	4 939.6	4 998.4	14 877.6
7	46 640.0	3 871.1	3 871.1	3 871.1	11 613.3	3 871.1	3 871.1	3 871.1	3 871.1	11 613.3	4 244.2	3 544.5	3 894.4	11 693.2	3 894.4	3 894.4	3 941.4	11 730.2
8	49 860.1	3 859.2	3 859.2	3 859.2	11 677.6	3 859.2	3 859.2	3 859.2	3 859.2	11 677.6	4 231.3	3 533.8	3 882.5	11 647.6	3 882.5	3 882.5	3 929.9	11 694.9
9	34 135.8	2 624.3	2 624.3	2 624.3	7 872.9	2 624.3	2 624.3	2 624.3	2 624.3	7 872.9	2 877.3	2 493.0	2 640.1	7 920.4	2 640.1	2 640.1	2 640.1	7 107.2
10	3 931.1	308.7	308.7	308.7	926.1	308.7	308.7	308.7	308.7	926.1	926.1	282.7	310.6	931.8	310.6	310.6	310.6	526.9
11	3 144.8	247.0	247.0	247.0	741.0	247.0	247.0	247.0	247.0	741.0	270.8	226.2	248.5	745.5	248.5	248.5	248.5	429.3
12	786.3	61.7	61.7	61.7	185.1	61.7	61.7	61.7	61.7	185.1	67.7	56.5	62.1	186.3	62.1	62.1	62.1	229.8
13	7 862.1	617.5	617.5	617.5	1 852.5	617.5	617.5	617.5	617.5	1 852.5	677.0	565.4	621.2	1 863.6	621.2	621.2	621.2	2 283.5
14																		
15																		
16																		
17																		
18																		
19																		
20	14 087.4	2 910.0	1 128.0	738.0	4 776.0	1 088.0	1 088.0	1 156.4	701.0	2 957.4	2 411.0	1 091.0	693.0	4 195.0	1 166.0	605.0	388.0	2 159.0
21	2 811.0	360.0	390.0	390.0	750.0	360.0	360.0	390.0	390.0	750.0	360.0	390.0	390.0	750.0	360.0	390.0	390.0	750.0
22	4 688.0	450.0	410.0	410.0	1 270.0	410.0	410.0	410.0	410.0	1 270.0	410.0	410.0	410.0	1 270.0	410.0	410.0	410.0	1 118.0
23	4 688.0	450.0	410.0	410.0	1 270.0	410.0	410.0	410.0	410.0	1 270.0	410.0	410.0	410.0	1 270.0	410.0	410.0	410.0	1 118.0
24																		
25	3 758.4	600.0	328.0	328.0	1 256.0	328.0	328.0	358.4	336.0	1 022.4	336.0	336.0	328.0	1 000.0	240.0	240.0	240.0	480.0
26																		
27	2 850.0	1 500.0			1 500.0					1 500.0				1 350.0				
28	3 299.0	615.0	260.0	260.0	615.0	260.0	260.0	260.0	260.0	615.0	260.0	260.0	260.0	615.0	260.0	260.0	260.0	674.0
29	1 874.0	240.0	250.0	250.0	500.0	240.0	240.0	260.0	260.0	500.0	240.0	260.0	260.0	500.0	374.0	374.0	374.0	374.0
30	1 425.0	375.0			375.0	375.0	375.0			375.0	375.0			375.0	300.0			300.0
31	427.4		225.0		225.0			135.0						67.4				
32																		
33	427.4		225.0		225.0			135.0						67.4				
34	10 830.6	43.8	8 000.0	2 664.3	10 708.1	43.8		135.0		43.8	43.8		67.4	43.8	34.9			34.9
35	6 000.0		6 000.0		6 000.0					6 000.0				6 000.0				
36	2 000.0		2 000.0		2 000.0					2 000.0				2 000.0				
37	664.3		664.3		664.3					664.3				664.3				
38																		
39	2 000.0		2 000.0		2 000.0					2 000.0				2 000.0				
40	166.3	43.8			43.8	43.8				43.8	43.8			43.8				43.8
41																		
42	7 600.0	2 000.0			2 000.0	2 000.0				2 000.0	2 000.0		1 600.0	3 600.0				
43																		
44	7 600.0	2 000.0			2 000.0	2 000.0				2 000.0	2 000.0		1 600.0	3 600.0				
45																		
46																		
47																		
48																		
49																		
50																		
51																		
52																		
53																		
54	6 000.0		3 000.0		3 000.0			3 000.0		3 000.0				3 000.0				
55	6 000.0		3 000.0		3 000.0			3 000.0		3 000.0				3 000.0				
56	6 000.0		3 000.0		3 000.0			3 000.0		3 000.0				3 000.0				
57	1 000.0		1 000.0		1 000.0			1 000.0		1 000.0				1 000.0				
58	1 000.0		1 000.0		1 000.0			1 000.0		1 000.0				1 000.0				
59	1 000.0		1 000.0		1 000.0			1 000.0		1 000.0				1 000.0				
60																		
61																		
62																		

Үүнээс:

Мөнгөн төгрөгөөр





